



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/05

Мөрөн

Сургалтын төлбөр төлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн нягтлан Х.Тунгалагзул нь СИ ТИ ЭС ХХК-ны Сангийн яам, Мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран зохион байгуулж буй “Нягтлан бодох бүртгэлийн программын шинэчлэл” сургалтанд хамрагдах тул сургалтын төлбөрт 220000 /хоёр зуун хорин мянган/ төгрөг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг Эрүүл мэндийн төвийн 210901 данснаас гаргахыг нягтлан бодогч (Х.Тунгалагзул) -д зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ



Б.ГАНДОЛГОР